

Smittskydd Skåne

Hepatit C

Өвчтөнд өгөх мэдээлэл ба өвчтөний баримтлах дүрэм. Халдвараас сэргийлэх эмчээс өгөх халдвараас сэргийлэх тухай мэдээлэл.

Гепатит C гэж юу вэ?

Гепатит C бол элгийг үрэвсүүлдэг вирус юм, гэхдээ ихэвчлэн хүндээ ямар нэгэн өвчлөлийн шинж тэмдэг өгдөггүй. Энэ халдвар өөрөө аяндаа арилж болох боловч ихэнхдээ элэгний архаг (заримдаа бүх насны) үрэвсэлтэй болгодог. Ийм үрэвсэлтэй удаан явбал элгэнд ноцтой байдал үүсэх магадлалтай. Тиймд гепатит C вирустай хүн эмчлэгч эмчтэйгээ тогтмол холбоотой байж, тус өвчнийг эмчлүүлэх боломжтой байвал тэр боломжоо алдаж болохгүй. Эмчилгээ амжилттай болсон тохиолдолд тус хүн бусдад халдваргүй болж, мөн өөрийнх нь элэг ч үргэлжлүүлж гэмтэл авахгүй. Ийм эмчилгээ, эмчийн үзлэг үнэгүй. Гепатит C вирус эмчлэгдсэн бол ахиад халдвар авахад ямар дархлаа үүсгэхгүй. Гепатит C вирусын эсрэг ямар нэгэн вакцин байхгүй.

Халдварлах зам

Гепатит C вирус цусаар халддаг. Мөн мансууруулах бодис хэрэглэгчийн тариур, мансууруулах бодисын шингэн хольсон сав, өөр хэрэгслээр халдаж болно. Зарим ховор тохиолдолд халдвартай цус бусдын салст бүрхэвч, ил шарханд хүрвэл халдана. Швед улсад 1992 оноос өмнө донорын цус, био-бүтээгдэхүүнээр халдвар авах эрсдэл байсан. Харин одоо түүнээс хойш бүх цусны бүтээгдэхүүнд гепатит C вирусын шинжилгээ хийдэг болсон тул ийм замаар халдвар магадлал тун бага. Мөн үтрээгээр хавьтахад халдах эрсдэл маш бага. Харин цус гарах, салст бүрхэвч гэмтэх магадлалтай тийм хавьталтын үед (жишээ нь шулуун гэдэсний хавьталт), мөн үүнээс гадна бэлгээр дамжих өөр халдвартай бол халдварлалын магадлал өндөрсөнө. Тиймд та түр зуурын хүнтэй хавьтах үед эсвэл цус гарах\салст бүрхэвч гэмтэх магадлалтай тийм төрлийн хавьталтын үед бэлгэвч хэрэглэх нь чухал. Эмэгтэй хүн углах бэлгэвч сайн хамгаалдаг байж болох боловч тус аргын үр дүнг одоогоор сайн судлаагүй байна. Бэлгэвчийн төрөл ямар байхаас шалтгаалахгүй бэлгэвчийг хавьталт эхлэхээс дуусах хүртэл нийт хугацаанд хэрэглэх ёстой.

Ямар үед Гепатит C вирус халдахгүй вэ?

Гепатит C вирус тэврэлт, хацрын үнсэлт эсвэл нулимсаар халдахгүй. Өтгөн, шээс, бөөлжис, нус цустай биш бол халдваргүй. Гэмтээгүй арьсанд цус хүрвэл бас халдахгүй.

Ажил мэргэжил эрхлэх үед

Гепатит C вирусын халдвар чиний ажил, сургуульд ихэнхдээ ямар нэгэн хязгаарлал үүсгэхгүй.

Жирэмсэн

Халдвартай эмэгтэй хүүхэддээ халдвар өгөх магадлал 5 хувиас бага. Тиймд жирэмслэх, хүүхэд хөхүүлэхэд тус халдвар ямар нэгэн хязгаарлал болохгүй.

Халдварыг мөрдөх

Халдвар авсан байж болох хүнийг олж, тэр хүнээр халдварыг цааш нь тараалгахгүй байх нь чухал. Тиймд халдварын мөрдөлт хийгддэг, чи хариуцсан мөрдөгчид нэгдүгээрт чамд халдаасан байж болох хүн\хүмүүсийн, хоёрдугаарт чи халдаасан байж болох хүн\хүмүүсийн нэр, холбогдох аргыг мэдэгдэх үүрэгтэй. Халдварын мөрдөлтөд чи хамтарч ажиллах үүрэгтэй. Ингэж холбогдсон хүмүүст чиний тухай мэдэгдэхгүй.

Smittskydd Skåne

Бусдад халдвар өгөхгүйн тулд чи ямар ариун цэврийн зөвлөмж дагах вэ

- Бага ч гэсэн шарханд заавал наалт наа.
- Хэрвээ өөр хүн чиний шархыг боовол тэр хүнийг резинэн бээлий хэрэглэ гэж хэл.
- Цус болсон зүйлийг сайн боож хая.
- Цус болсон хувцсыг угаалгын машинаар угаа.
- Жишээ нь шалан дээр цус гоожвол арчаад, арчсан материалыг хаяж, дараа нь шалыг ус, цэвэрлэх бодисоор сайн угаа.

Бусдад халдвар өгөхгүйн тулд чи ямар мөрдөх дүрэм дагах вэ

- Чиний эмчлэгч эмч чамайг эргэж ирэх шаардлагатай гэвэл чи заавал очих ёстой.
- Чи эмнэлэг, шүдний эмнэлэгт хандвал өөрийгээ халдвартайг мэдэгдэх ёстой.
- Чи цус гарах магадлалтай үед, жишээ нь шивээс хийлгэх, чих цоолуулах, биеийн бусад хэсэгт нүх гаргуулахад өөрийгээ халдвартайг мэдэгдэх ёстой.
- Чиний цус өөр хүний ил шарх, нүд, хамар, аманд орвол тэр дор нь усаар зайлуул. Мөн цусаа гепатит С вирусын халдвартай тухай, тэр хүнийг аль болох хурдан хэсгийн эмнэлэг, халдвартын тасаг, 1177 (эрүүл мэндийн лавлах) руу хандах ёстойг мэдэгдэх ёстой.
- Чи сахлын хутга, шүдний сойз зэрэг ариун цэврийн зүйлээ өөр хүнтэй хувааж хэрэглэж болохгүй.
- Чи мансууруулах бодис судсандаа тарьдаг бол өөрийн тариуртай байж, хэрэглэсэн тариурыг өөр хүнд хэрэглүүлэхгүй байна. Мансууруулах бодисын шингэн хольсон сав \ өөр хэрэгслийг өөр хүнтэй хувааж хэрэглэж болохгүй. Эдгээр хэрэгслийг хадгалахад халдваргүй байлгана.
- Чи донорын журмаар цус, эр үрийн шингэн, эм өндөг, биеийн эрхтэн, биеийн эд бусдад хандивлаж болохгүй.
- Цус гарах\салст бүрхэвч гэмтэх магадлалтай тийм төрлийн хавьталтын үед хавьталтад орохын өмнө өөрийгээ гепатит С вирусын халдвартайг мэдэгдэх ёстой. Чи бэлгэвч (аль ч төрлийн) хэрэглэх байсан ч өөрийгээ гепатит С вирусын халдвартайг мэдэгдэх ёстой.
- Үтрээ, шулуун гэдэс, аманд эр эрхтэн орсон маягаар хавьтахад цус гарах\салст бүрхэвч гэмтэх магадлалтай тул хавьталт эхлэхээс дуусах хүртэл бэлгэвч хэрэглэх ёстой.

Гепатит С вирусын халдвар бол тус улсын халдвараас сэргийлэх хуулийн дагуу олон нийтэд аюултай гэж тооцогддог өвчин юм. Тиймд чи эмчийн заасан мөрдөх журмыг дагах үүрэгтэй. Хэрвээ чи өөрт хамаатай мөрдөх журмыг өөрчлүүлэх хүсэлтэй бол аймгийн халдвараас сэргийлэх эмчид хандаж болно.